



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 3 сарын 17 өдөр

Дугаар 09/142

Номгон

「Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын
цэргийн албаны үйл ажиллагаатай
танилцах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/28 дугаар тогтоолын 2-р хавсралт аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний 29 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Батлан хамгаалах зарим чиг үүргийг Баянхонгор аймагт төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээний 4.6-д заасны дагуу 2024 оны хоёрдугаар ээлжээр Зэвсэгт хүчин, Дотоодын цэрэгт татагдан хугацаат цэргийн алба хааж буй дайчидтай уулзалт зохион байгуулах, цэргийн албаны үйл ажиллагаатай батлан хамгаалах товчооны гишүүд, ар гэрийн төлөөлөл танилцах ажлыг зохион байгуулж явуулсугай.

2. Дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах төлөвлөгөөг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн хугацаат цэргийн албыг нэр төртэй хааж байгаа дайчидтай уулзалт зохион байгуулах, цэргийн албаны үйл ажиллагаатай танилцахад шаардагдах 20.000.000 (Хорин сая) төгрөгийг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.

4. Тус арга хэмжээг заасан хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, мэдээллээр ханган ажиллаж, тайлагнахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН


625010417
W:\2025 ON\ZAKHIRAMJ\ЗАХИРАМЖ\11.DOCX1

Аймгийн Засаг даргын ...-ны ... дугаар
сарын ...-ны өдрийн ... дугаар захирамжийн
... дүгээр хавсралт

ДАЙЧДЫГ ЭРГЭХ, ЦЭРГИЙН АЛБАНЫҮЙЛ
АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ ХӨТӨЛБӨР

д/д	Явагдах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4
1	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн анги, салбарын бүрэлдэхүүнтэй мэндчилэх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулах	5 минут	Зэвсэгт хүчний анги
2	Ангийн үйл ажиллагаатай танилцах	20 минут	Зэвсэгт хүчний анги
3	Ажлын хэсгийн ахлагч бие бүрэлдэхүүнд мэндчилгээ дэвшүүлэх	5 минут	Зэвсэгт хүчний анги
4	Ангийн бүрэлдэхүүн урлагийн номер үзүүлэх	10 минут	Зэвсэгт хүчний анги
5	Аймгийн Засаг даргын болон цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүн дайчдад гарын бэлгийг гардуулж өгөх	15 минут	Зэвсэгт хүчний анги
6	Зэвсэгт хүчний ангид Баянхонгор аймгийн Засаг Тамгын газраас дурсгалын зүйл гардуулах	5 минут	Зэвсэгт хүчний анги
7	Ангийн удирдлагууд бие бүрэлдэхүүнд хандаж мэндчилгээ дэвшүүлэх	3 минут	Зэвсэгт хүчний анги
8	Ажлын хэсэг ангийн бүрэлдэхүүнтэй дурсгалын зураг татуулах	3 минут	Зэвсэгт хүчний анги
9	Хөтөлбөрийн дагуу дараагийн анги руу хөдөлгөөн үйлдэх	-	Ажлын хэсэг

Аймгийн Засаг даргын-ны дугаар
сарын 17-ны өдрийн дугаар захирамжийн
.....2..... дугаар хавсралт



ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Б.Наранбаяр

Аймгийн Засаг даргын орлогч,

Д.Энхжаргал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, цэрэг
татлагын товчооны дарга

Орлогч дарга:

Г.Нэмэхбаяр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын дарга, хурандаа

Нарийн бичгийн дарга

Т.Мөнхбат

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын дайчилгааны офицер, дэд хурандаа

Гишүүдэд:

Г.Бат-Өлзий

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл
сургалтын офицер, хошууч

- Сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар – 20 хүн

- Зураглаач – 1 хүн

- Урлагийн номер толилуулах бүрэлдэхүүн – 5 хүн

- Ар гэрийн төлөөлөл -20

- Жолооч – 3 хүн

оОо

Аймгийн Засаг даргын ... оны ... дугаар
сарын 17 -ны өдрийн ... дугаар захирамжийн
... дугаар хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Зардлын тооцоо		
		Тоо	Нэг бүрийн дүн	Нийт дүн
1	Best seller ном	90	30.000	2.700.000
2	Тэмдэглэлийн дэвтэр	90	10.000	900.000
3	Бугуйн цаг	90	35.000	3.150.000
4	Ундаа-4500 Шоколад-9500 Самар-8500 Печень-10500 Тамхи-6200 Гаа-7500 Оймс-3300	90	50.000	4.500.000
5	Ус буцалгагч /ангид/	8	110.000	880.000
6	Индүү /ангид/	8	91.900	735.200
7	Баллонтой ус буцалгагч /ангид/	8	210.000	1.680.000
8	Ангид дурсгалын зүйл	8	300.000	2.400.000
9	Шатахуун /4 машин/	1450 км /290 л/ /Land criuser 200/	2530 төг	733.700 төг
		1450 км /290 л/ /Land criuser 200/	2530 төг	733.700 төг
		1450 км /290 л/ / Land criuser 76/	2530 төг	733.700 төг
		1450 км /290 л/ /УАЗ пургон/	2530 төг	733.700 төг
10	Масло	8 л	15.000	120.000 төг
Нийт дүн			20.000.000 төг	

оОо

